

## ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургуулийн нийгмийн ажилтнаас ахлах ангийн сурагчдад зориулсан сургалтын модуль

Р.Туяа Ph.D

/БМДИ-ийн албаны дарга/ [tuya@itpd.mn](mailto:tuya@itpd.mn)

**Модулийн зорилго:** Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтанд БШУ-ны сайдын 2020 оны Б/03 тоот “Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай” тушаалын гурав дугаар хавсралт “ЕБС-н нийгмийн ажилтны албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт”-д заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга аргачлал эзэмшүүлэхэд оршино.

**Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:** ЕБС-ийн нийгмийн ажилтан та энэхүү модулийг хэрэгжүүлэхдээ дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.Үүнд:

- АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном, багшийн гарын авлага, сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж тус бүртэй нарийвчлан танилцаж судалсан байх
- Өөрийн албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтын зорилго болох “Боловсролын салбарын болон хүүхэд хөгжил, хамгааллын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулах” гэж заасныг үндэслэн сургуулийн хэмжээнд ахлах ангийн сурагчдад хичээлээс гадуур зохион байгуулж буй ажлын үр дүнг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгод нийцүүлэн ажлаа төлөвлөх
- Албан тушаалын хоёр дугаар зорилт болох “Хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх” ажлын хүрээнд:
  - Ахлах ангийн сурагчид өөрийн хүссэн мэргэжлээ эзэмшихэд тухайн судлагдахууны багшийн сургалтын чанар, заах арга зүй оновчтой байгаа эсэхэд сургалтын менежертэй хамран ажиллаж хүүхдийн эрхийг хамгаалах
  - Тухайн сурагчийн авьяас чадварын талаар эцэг эх асран хамгаалагчдад мэдээлэл хүргэж мэргэжлээ сонгох, шийдвэр гаргахад хамтран мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
  - Ахлах ангийн цэцэг эхчүүдэд хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн үеийн чиг хандлага, бодит нөхцөл байдлын талаар орон нутгийн захиргаатай хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран үйлчилгээ үзүүлэх
  - Ахлах анги удирдсан багш нартай хамтран сурагчдаас ажил мэргэжлийн судалгаа авах
  - Сурагчдын ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн хичээл сонголт хийхэд сурагчдад зөвлөн тусалж хүүхдийн эрхийг хамгаалах
  - Сурагчдад ажил мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх

- Албан тушаалын гурав дугаар зорилт болох “Хүүхдийн хөгжил, төлөвшилт, сонирхол хэрэгцээнд тулгуурлан хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, арга зүйн удирдлагаар хангах” ажлын хүрээнд:
  - Ахлах ангийн эцэг эхчүүдтэй хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжил сурталчлах ажлыг сургуулийн хэмжээнд нэгдсэн байдлаар анги удирдсан багш нартай хамтран зохион байгуулах
  - Ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах
  - Сурагчдын хэрэгцээ сонирхолд үндэслэн өөрийн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус байгууллагатай хамтран ажлын байрны сургалт үйл ажиллагаа зохион байгуулах
  - Сургууль дээр ажиллаж буй сурагчийн өөрийн удирлагын байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сурагчдын авьяас чадварыг нээх, цаашид мэргэжлээ зөв сонгоход чиглүүлж, арга зүйн удирдлагаар хангах
  - Ажил мэргэжлээ сонгоход өөрийн орон нутгийн хэрэгцээ шаардлага ажлын байрыг сурагчидтай хамтран судлах
  - Сурагчдын дунд мэргэжлийн багш нартай хамтран ажил мэргэжлийн чиглэлээр эссэ, уралдаан зохион байгуулж, илтгэл судалгааны ажил өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх
  - Ажил мэргэжлийн чиглэлээр сургууль дээр тусгайлсан мэдээллийн самбар ажиллуулах
  - Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулиар зочлон танилцах ажил зохион байгуулах
  - Өөрийн сургуулийн төгсөгч болон тухайн мэргэжлээр суралцаж буй оюутантай уулзалт зохион байгуулах
  - Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжааны хүрээнд өөрийн танилцуулга бичих, өргөдөл гаргах, ярилцлагад орох талаар мэдлэг мэдээлэлтэй болоход дэмжлэг үзүүлэх ажлыг анги удирдсан багштай хамтран зохион байгуулах
  - Тухайн ажил мэргэжлийг эзэмшихэд шаардлагатай хувь хүний ур чадвараа дээшлүүлэхэд зориулсан сургалт үйл ажиллагаанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах зэрэг ажил үүргийг гүйцэтгэх шаардлагатай болно.

**Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн загвар:**

Сургуулийн нийгмийн ажилтан та өөрийн сургуулийн алсын хараа, эрхэм зорилго болон тухайн хичээлийн жилийн зорилго, зорилтод нийцүүлэн өөрийн ажлыг төлөвлөн гаргаж байгаа. Энэ ажлын төлөвлөгөөндөө ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж буй танхимын болон танхимын бус үйл ажиллагааг тодорхой тусгаж, үр дүн нь сурагчдад гарах ахиц амжилтаар тооцогдох шаардлагатай. Иймд ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сургууль дээр 10-12 дугаар ангийн сурагчдын дунд нэгдсэн байдлаар зохион байгуулах тухайлсан ажлын хөтөлбөрийн загварыг дараах хүснэгтээр үзүүллээ.

**“Ажлын байран дээрх сургалт үйл ажиллагаа” зохион байгуулах хөтөлбөр**

**Хөтөлбөрийн зорилго:** ..... сургуулийн ахлах ангийн сурагчдаас авсан ажил мэргэжлийн чиг баримжааны судалгаанд үндэслэн аймгийн төвийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан мэдлэг мэдээлэлтэй болно.

**Зорилтот бүлэг:** .....сургуулийн 10-12 ангийн эмч, сувилагчийн мэргэжил сонгосон нийт 38 сурагч

**Зохион байгуулагч:** ..... сургуулийн нийгмийн ажилтан, 10-12 ангийн анги даасан багш нар

**Хугацаа:** Танхимын бус сургалт: 2021 оны 09 сарын 28 14-16.30 цаг

Танхимын сургалт: 2021 оны 09 сарын 30

**Хүлээгдэж буй үр дүн:** Сурагчид өөрийн сонгосон мэргэжлийн ажлын байртай танилцсанаар мэргэжил сонголтод үнэлгээ дүгнэлт хийсэн байна.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын нөөц	Хүрсэн үр дүн /%-иар/
1	Нэгдсэн эмнэлгийн удирдлагатай уулзах	14.00-14.20	Эмнэлгийн даргын өрөө	
2	Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах	14.20-15.00	Нэгдсэн эмнэлэг	
3	Эмч, сувилагчийн ажлын байртай танилцах	15.00-15.50	4 эмч, 4 сувилагч тус бүр дээр сурагчид хуваагдах	
4	Өөрийн сургуулийг төгсөгч эмчтэй уулзалт хийх	15.50-16.20	Нэгдсэн эмнэлгийн уулзалтын танхим	
5	Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах ажиллагааг дүгнэх	16.20-16.30	Нэгдсэн эмнэлгийн хүлээлгийн танхим	
6	Сурагчид өөрсдийн сэтгэгдэл бичих	9 сарын 29	Сурагч бүрийн эссэ	
7	Бичсэн сэтгэгдлээ хуваалцах уулзалт зохион байгуулах	9 сарын 30	Сургуулийн хурлын танхим	
8	Үйл ажиллагааны дүгнэлт, үнэлгээ	9 сарын 30	Сургуулийн хурлын танхим	

Хөтөлбөр боловсруулсан ..... /...сургуулийн нийгмийн ажилтан /

Хөтөлбөртэй танилцсан: ...../ .... ангийн багш /

...../ .... ангийн багш /

**Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлээр ахлах ангийн сурагчдын эзэмшсэн мэдлэг чадварт дэмжлэг үзүүлэх:** Сургуулийн нийгмийн ажилтан та ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ахлах ангийн суралцагчийн гарын авлагаар сурагчид ямар мэдлэг, чадвар эзэмшиж байгааг судлан танхимын болон танхимын бус аргаар анги удирдсан багш, эцэг

эх, сургуулийн удирдлагуудтай хамтран сурагчдад хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар энэ хэсэгт дурдах болно.

**10 дугаар анги:** / Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

**Зорилго:**

- Сурагчид 9 дүгээр ангид хийсэн сонголтоо эргэн харах, дүгнэх
- Ажил мэргэжлийн талаар илүү бодитой ойлголттой болох
- Ирээдүйгээ төсөөлөх
- Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлах
- 11 дүгээр ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох

Дасгал	Сурагчдын эзэмшиж буй мэдлэг	Сурагчдын эзэмшиж буй чадвар	Нийгмийн ажилтны үзүүлэх дэмжлэг
1. Ахлах ангийн хичээлийг ажил мэргэжилтэй уялдуулах	Тухайлсан нэг хичээл судалснаар ямар мэргэжилтэй болох талаар мэдэх	Хичээл мэргэжил хоорондын уялдаа холбоог судлах	Ахлах ангид хичээл ордог багш нарт өөрийн хичээлийг нь судалснаар ямар мэргэжилтэй болох боломжтой талаар сурагчдад мэдээлэл хүргэх
2. Ажил мэргэжлийг ахлах ангийн хичээлтэй уялдуулах	Тухайлсан нэг мэргэжил эзэмшихэд ямар хичээлийг судлах талаар мэдэх	Мэргэжил ба хичээл хоорондын уялдаа холбоог судлах	Ахлах ангийн сурагчдад өөрийн сонгосон мэргэжлээр ямар хичээлийг заавал судлах ямар сургуульд элсэх боломжтой талаар мэдээлэл өгөх
3. Ажил мэргэжил болон эзэмших боловсрол	Сурагчийн сонгосон мэргэжил эзэмшихэд зайлшгүй эзэмших боловсролын талаар мэдэх	Сонгосон мэргэжлийн дагуу эзэмших боловсролын судалгаа хийх	Сургуулийн хэмжээнд хийсэн ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн сургалт, өдөрлөг зохион байгуулах
4. Ажил мэргэжил ба боловсрол эзэмших судалгаа	Сурагч сонгосон мэргэжлээ эзэмших сургалтын хөтөлбөр зардал хугацааг тооцоолох талаар мэдэх	Сонгосон мэргэжлээ эзэмших боломж сургалтын хөтөлбөр, зардал, хугацааг тооцоолох судалгаа хийх	Тухайлсан нэг мэргэжлийг эзэмших боломжуудыг судалсан талаар мэдээлэл хүргэх
5. Боловсрол сургалтын олон янзын боломж	Сурагч сонгосон мэргэжлээр ажиллах боломж гарах зардлын талаар мэдэх	Сонгосон мэргэжлээр ажиллах боломжтой байгууллагын судалгаа, гарах зардлын тооцоо гаргах	Тухайн мэргэжлээр ажиллах боломжтой байгууллага ажлын байранд тавигдах шаардлагын талаар мэдээлэл хүргэх
6. Ажил мэргэжлийг таньж мэдэх	Сурагчдад сонгосон ажил мэргэжлүүдийн ижил төстэй ялгаатай байдлыг мэдэх	Ажил мэргэжлүүдийн ижил төстэй ялгаатай байдлыг судлах	Сурагчдад ижил төстэй ажил мэргэжлийн судалгаа хийж мэдээлэл хүргэх
7. Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авах эх сурвалж	Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авах эх сурвалжийг мэдэх	Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авах эх сурвалжийн талаар судалгаа хийх	Судлагдахууны багш нартай хамтран судалгаа хийж мэдээлэл хийх

8. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ажил мэргэжил	Эрэгтэй эмэгтэй хүний ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох	Эрэгтэй эмэгтэй хүний ажил мэргэжлийн талаарх судалгаа хийх	Ажлын байранд сургалт хийх ажил зохион байгуулах
9. Ажил амьдралын үүргээ таньж мэдэх	Амьдралын зорилгоо тодорхойлох ирээдүй төсөөлөх	Сурагчид өөрийн 30 насны амьдралаа төсөөлөх түүнд хүрэх аргаа тодорхойлох	Ахлах ангийн сурагчдад амьдрах ухааны талаарх мэдлэг ойлголт өгөх сургалт зохион байгуулах

**11 дугаар анги:** / Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

**Зорилго:**

- Сурагчид 10 дугаар ангид хийсэн төлөвлөгөөгөө эргэн харах, дүгнэх
- Дээд боловсрол, мэргэжлийн боловсролын хөдөлмөрийн зах зээлийн талаарх ойлголттой болох
- Ажил мэргэжлийн сонголт ижил төстэй шинжүүдтэй танилцах
- Ажил мэргэжлийн талаарх шийдвэр гаргах
- Их дээд сургуульд элсэх талаар сонголт хийх шийдвэр гаргах

Дасгал	Сурагчдын эзэмшиж буй мэдлэг	Сурагчдын эзэмшиж буй чадвар	Нийгмийн ажилтны үзүүлэх дэмжлэг
1. Ажлын шаардлага	Ажилд авах зартай танилцан тухайн ажлын байранд тавигдах шаардлагын талаар мэдэх	Өөрийн сонгосон мэргэжилд тавигдах шаарлагын талаар судлах	Ажил мэргэжилд тавигдах суурь шаардлагын тухай болон тухайн мэргэжил эзэмшсэн хүнтэй уулзалт зохион байгуулах
2. Миний хувийн намтар	Сурагч өөрийн сонгосон мэргэжилд тохирох ур чадвартай эсэхээ мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжилд тохирох ур чадвараа үнэлж өөрийн үнэлгээ хийх	Ахлах ангийн сурагчдад өөрийн сонгосон мэргэжлээр ажиллахад дэмжлэг үзүүлж амьдрах ухааны суурь мэдээлэл өгөх
3. Оюун ухааны хэв шинж	Сурагчийн сонгосон мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай оюун ухааны хэв шинжийн талаар мэдэх	Сонгосон мэргэжлийн дагуу оюун ухааны хэв шинжээ үнэлж өөрийн үнэлгээ хийх	Ахлах ангийн сурагчдад өөрийн сонгосон мэргэжлээр ажиллахад дэмжлэг үзүүлж амьдрах ухааны сургалт зохион байгуулах
4. Ажил мэргэжлийн товч төлөвлөгөө	Сурагч сонгосон мэргэжлээ эзэмших товч төлөвлөгөөний талаар мэдэх	Сонгосон мэргэжлээ эзэмших товч төлөвлөгөөний гаргах	Хэрхэн төлөвлөгөө боловсруулах талаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
5. Ажил мэргэжлийн төлөвлөгөөний хүснэгт	Сурагч сонгосон мэргэжлээ эзэмших төлөвлөгөөний хүснэгтийн талаар мэдэх	Өөрийн сонгосон мэргэжил эзэмших хүснэгт хийж судлах	
6. Ажил мэргэжлийн төлөвлөгөөний үргэлжлэл	Сурагч сонгосон мэргэжлээ эзэмшээд ямар үйл ажиллагаа хийх талаар мэдэх	Сонирхсон мэргэжлийн ажлын байранд судалгаа хийх	Ажлын байранд сургалт хийх

7. Ажил мэргэжлийн хоёр дахь сонголт	Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авах эх сурвалжийг мэдэх	Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авах эх сурвалжийн талаар судалгаа хийх	Судлагдахууны багш нартай хамтран судалгаа хийж мэдээлэл хийх
8. Ажил мэргэжлийн гурав дахь сонголт	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмшихэд хамгийн түрүүнд юу хийх шаардлагатайг мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмшихэд хамгийн түрүүнд хийх шаардлагата зүйлээ хэрэгжүүлэх дадлага сургалтад хамрагдах	Сургуулийн ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн уулзалт, танхимын сургалт, ажлын байран дээрх сургалт, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах
9. Ажил мэргэжлийн дөрөв дэх сонголт			
10. Ажил мэргэжлийн тав дахь сонголт			
11. Ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргахад ашиглах цахим эх сурвалж	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээр судалгаа хийх мэдлэгтэй болох	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээр судалгаа хийх	Судалгааны ажлын талаарх мэдлэг ойлголт өгч мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
12. Ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргахад ашиглах бусад эх сурвалж	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээр цахим болон ном гарын авлагаас судалгаа хийх, түүнд шүүн тунгаах, шийдвэр гаргах	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээр судалгаа хийж, түүнээс шүүн тунгаах, шийдвэр гаргах чадвартай болох	Ахлах ангийн сурагчдад өөрийн сонгосон мэргэжлээр ажиллахад дэмжлэг үзүүлж амьдрах ухааны сургалт зохион байгуулах
13. Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхэд ашиглах ном гарын авлага			

**12 дугаар анги:** /Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

**Зорилго:**

- Сурагчид 11 дугаар ангид хийсэн төлөвлөгөөгөө эргэн харах, сайжруулах
- Дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургуульд өргөдөл гаргах
- Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх
- Тодорхойгүй нөхцөл байдалд шийдвэр гаргах

Дасгал	Сурагчдын эзэмшиж буй мэдлэг	Сурагчдын эзэмшиж буй чадвар	Нийгмийн ажилтны үзүүлэх дэмжлэг
1.12 дугаар анги төгссөний дараах ажил мэргэжлийн чиглэл	Сурагч өөрт тохирох 3-5 мэргэжил сонгох	Мэргэжил бүр дээр ямар чадвар эзэмших, энэ нь өөрт байгаа эсэхэд үнэлгээ өгөх	Гарын авлага ашиглан ямар мэргэжилд ямар чадвар шаардлагатайг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
2. Төрийн өмчийн их дээд сургуульд суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших их дээд сургуулийг судлан суралцах хугацаа,	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших их дээд сургуулийг судлан суралцах хугацаа,	Сургуулийн ахлах ангийн сурагчдаас авсан ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн их дээд сургуулийн мэргэжлийн ангийн мэдээлэл
3. Хувийн их дээд сургуульд			

суралцах төлөвлөгөө	гарах зардал, ажлын байрны талаар мэдэх	гарах зардал, ажлын байрны талаар судалгаа хийж шийдвэр гаргах	хүргэх, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах
4. Төрийн өмчийн мэргэжлийн боловсролын сургуульд суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших мэргэжлийн боловсролын сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших мэргэжлийн боловсролын сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар судалгаа хийж шийдвэр гаргах	Сургуулийн ахлах ангийн сурагчдаас авсан ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн ангийн мэдээлэл хүргэх, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах
5. Хувийн мэргэжлийн боловсролын сургуульд суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших мэргэжлийн боловсролын сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших мэргэжлийн боловсролын сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар судалгаа хийж шийдвэр гаргах	Сургуулийн ахлах ангийн сурагчдаас авсан ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн ангийн мэдээлэл хүргэх, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах
6. Төрийн болон хувийн их дээд сургуульд эчнээгээр суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн хүссэн мэргэжлээрээ хэрэв өдрөөр суралцах боломжгүй бол эчнээгээр хэрхэн суралцаж болох талаар мэдээлэлтэй болох	Сурагч өөрийн хүссэн мэргэжлээрээ хэрэв өдрөөр суралцах боломжгүй бол эчнээгээр суралцах талаар судалгаа хийх	Сургуулийн ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн их дээд сургууль, мэргэжлийн сургуультай танилцах, ажлын байран сургалт хийх, төгсөгчтэй уулзах ажлыг удирдан зохион байгуулах
7. Төрийн болон хувийн мэргэжлийн боловсролын сургуульд эчнээгээр суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн хүссэн мэргэжлээрээ хэрэв өдрөөр суралцах боломжгүй бол эчнээгээр хэрхэн суралцаж болох талаар мэдээлэлтэй болох	Сурагч өөрийн хүссэн мэргэжлээрээ хэрэв өдрөөр суралцах боломжгүй бол эчнээгээр суралцах талаар судалгаа хийх	Сургуулийн ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн их дээд сургууль, мэргэжлийн сургуультай танилцах, ажлын байран сургалт хийх, төгсөгчтэй уулзах ажлыг удирдан зохион байгуулах
8. Зайн цахим сургалтад суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжилд тохирох ур чадвараа хөгжүүлэхэд урт богино хугацааны зайн сургалтын талаар мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжилд тохирох ур чадвараа хөгжүүлэхэд урт богино хугацааны зайн сургалтын судалгаа хийж хамрагдах	Хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалтыг зохион байгуулах
9. Орон нутагтаа хөдөлмөр эрхлэх	Сурагч өөрийн хүссэн сургууль мэргэжлээ эзэмшихэд тухайн жилдээ амжаагүй тохиолдолд орон нутагтаа юу хийх боломж байгаа талаар мэдэх	Сурагч өөрийн орон нутагтаа ямар хөдөлмөр эрхлэх боломж байгаа судлах	Орон нутгийн хөдөлмөр эрхлэх хэлтэстэй хамтран ажил зохион байгуулах
10. Хувиараа хөдөлмөр эрхлэх	Сурагч өөрийн хүссэн сургууль мэргэжлээ эзэмшихэд тухайн жилдээ амжаагүй тохиолдолд орон нутагтаа юу хийх боломж байгаа талаар мэдэх	Сурагч өөрийн орон нутагтаа ямар хөдөлмөр эрхлэх боломж байгаа судлах	Орон нутгийн хөдөлмөр эрхлэх хэлтэстэй хамтран ажил зохион байгуулах
11. Өөрийгөө сурталчлан танилцуулах	Өөрийн танилцуулга, өөрийгөө илэрхийлэхэд шаардлагатай мэдлэг мэдээлэлтэй болох	Өөрийгөө илэрхийлэх чадварт суралцах	Хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт үйл ажиллагаа зохион байгуулах

12. Ажилгүй нөхцөл байдлаа удирдах	Олон нийтийн сүлжээ, амьдралын зорилго, зохион байгуулалттай байх мэдлэг ойлголттой болох	Олон нийтийн сүлжээнд байх, амьдралын зорилгоо тодорхойлж зохион байгуулалттай байх чадварт суралцах	
------------------------------------	---	--	--

**Модуль хэрэгжүүлэх арга зүй:** Сургуулийн нийгмийн ажилтан та ахлах ангийн сурагчид ажил мэргэжлийн талаар ямар мэдлэг ойлголттой болох агуулга болон түүнд нийгмийн ажилтан хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар тодорхой мэдээлэлтэй боллоо. Харин энэ хэсэгт дээрх дэмжлэг болох ажлаа ямар арга зүйгээр зохион байгуулах боломжтой талаар мэдээлэл хүргэх гэж байна. Энэ нь 10-12 анги тус бүрдээ тухайн насны хүүхдийн зорилго, насны онцлогоос хамааран зохион байгуулж буй ажил нь ялгаатай байх боломжтой. Мөн тодорхой нэг ажлыг 10-12 ангийн сурагчдад өөр өөр арга зүйгээр оролцоонд тулгуурлан зохион байгуулах боломжтой. Иймд анги тус бүр дээр ямар арга зүй хэрэглэх талаар дараах хүснэгтэд загвар гарган хүргэж байна.

10 дугаар анги	11 дүгээр анги	12 дугаар анги
<ul style="list-style-type: none"> <li>▪ Багаар ажиллах</li> <li>▪ Судалгаа шинжилгээ хийх</li> <li>▪ Инсертийн арга</li> <li>▪ Ярилцлага арга</li> <li>▪ Харьцуулан дүгнэх</li> <li>▪ Дүрд тоглох арга</li> <li>▪ Төсөөлөх арга</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багаар ажиллах</li> <li>▪ Судалгаа шинжилгээ хийх</li> <li>▪ KWL арга</li> <li>▪ Өөрийгөө илэрхийлэх</li> <li>▪ Жишээнд суралцах</li> <li>▪ Задлан шинжлэх</li> <li>▪ Уншигчдын семинар хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багаар ажиллах</li> <li>▪ Судалгаа шинжилгээ хийх</li> <li>▪ Хамтран суралцах арга</li> <li>▪ Бүлэглэх арга</li> <li>▪ Илтгэх урлаг</li> <li>▪ Газар орноо судлах</li> <li>▪ Бүтээлийн сан ажиллуулах</li> </ul>

**Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа зохион байгуулагдсаны үр дүн:** Сургуулийн нийгмийн ажилтан та өөрийн сургуулийн ахлах ангийн сурагчдад багш, эцэг эх, сургуулийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүн нь дараах байдлаар харагдана. Үүнд:

- Танай сургуулийг тухайн хичээлийн жилд төгссөн сурагчид мэргэжлийн сургуульд элсэн орсон үзүүлэлтэд ахиц гарсан.
- Танай сургууль төгссөн сурагчдийн мэргэжилтэй ажилтан болсон тоон үзүүлэлтэд ахиц гарсан байна.
- Ахлах ангийн сурагчдын хичээл сонголт тогтворжсон байна.
- Ахлах ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр ямар мэргэжил эзэмших талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Ахлах ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр эзэмших мэргэжлийг аль их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуульд эзэмшиж болох талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Ахлах ангид хичээл зааж буй багш нарын заах аргад ахиц гарсан байна.
- Ахлах ангийн сурагчид өөрийн зорилготой болж бие даах чадварт ахиц гарсан байна.

- Ахлах ангийн сурагчдын хичээлд оролцох оролцоо сургалтын чанарт ахиц гарсан байна.

**Модуль боловсруулахад болон хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, ном зүй:**

**Гарын авлага:** АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

**Цахим эх сурвалж:**

- [www.mergejil.mn](http://www.mergejil.mn)
- [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- [www.onisep.fr](http://www.onisep.fr)
- [www.myworldofwork.co.uk](http://www.myworldofwork.co.uk)
- [www.careers.govt.nz](http://www.careers.govt.nz)
- <https://myfuture.edu.au>
- <https://www.onetonline.org>
- <https://www.onetonline.org>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион

байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ